



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 5/162.

Алтанбулаг

Г Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.7, 9.9, 23 дугаар зүйлийн 23.4 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны “Бруцеллөзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/166 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/329 тоот захирамж, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын “Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А/19 дүгээр тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ү.Янжиндулам (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга

М.Цэгмид (МЭТ-н Тархварзүйч)

Гишүүд

Э.Зориг (1 дүгээр багийн Засаг дарга)  
Н.Мөнхзул (2 дугаар багийн Засаг дарга)  
Г.Мөнхболд (3 дугаар багийн Засаг дарга)  
Р.Булгаа (“Бөхлөө-хангай” ХХК-ийн захирал)  
Л.Гантэмэр (“Бумбат-өлгий” ББН-ийн захирал)

2. Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.

3. Сумын хэмжээнд адуунаас бусад мал сүргийн охин төлийг бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад бүрэн хамруулах ажлыг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 14 хоногийн дотор шуурхай, чанартай зохион байгуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

4. Био бэлдмэлийг татан төвлөрүүлж, тараан олгож, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, дархлаажуулалтын ажлын явцад хяналт тавьж, тайлан мэдээг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (М.Цэгмид)-д үүрэг болгосугай.

5. Бруцеллёэз өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг батлагдсан хуваарийн дагуу технологит хугацаанд шуурхай зохион байгуулах, уг арга хэмжээний ач холбогдол, Бруцеллёэз өвчний хор уршгийн талаар ухуулга, сурталчилгаа хийх ажлыг багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч наарт даалгасугай.

6. Дээрх арга хэмжээг мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж, мал эмнэлгийн цахим системд төлөвлөгөөг бүрэн оруулж, үр дүн гүйцэтгэлд хяналт тавьж, дархлаажуулалтын явцын мэдээг 7 хоног бүр сумын Засаг дарга, аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж ажиллах, уг арга хэмжээний дараа санхүүжилтийн материалд хяналт тавьж баталгаажуулах, цахим системд гүйцэтгэл тулгаж баталгаажуулах ажлыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (М.Цэгмид)-д даалгасугай.

7. Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлс хийсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцохыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын тамгын газрын дарга (Ү.Янжиндулам)-т үүрэг болгосугай.

8. Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Х.Огтонжаргал)-д даалгасугай.

